



ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН ЯАМ
СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ
ТӨВИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН
ТУШААЛ

2016 оны 06 сарын 06 өдөр

Дугаар А/53

Улаанбаатар хот


□ Чөлөө олголтонд зохицуулалт хийх тухай □

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 80.1, Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.1, Удирдлагын зөвлөлийн гишүүдийн 2016 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТУШААХ НЬ:


1. Чөлөө олголттой холбоотой ирсэн удаа дараагийн гомдлын дагуу хэлэлцэн шийдвэрлэж Хөдөлмөрийн дотоод журмын 6.8, 6.9, 6.10 дахь заалтуудад өөрчлөлт оруулан хавсралтаар баталсугай.

2. Энэ тушаалыг хэрэгжүүлэн, мөрдөж ажиллахыг Стратеги төлөвлөлт, хүний нөөцийн хөгжлийн албаны дэд захирал, ахлах мэргэжилтэн, мэргэжилтнүүдэд үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Л.НАСАНЦЭНГЭЛ



Цалинтай чөлөө олгох үндсэн шалтгаанууд

Дараахи тохиолдолд цалинтай чөлөө олгоно.

1. Төрүүлсэн эцэг, эх, нөхөр, эхнэр, үр хүүхэд, хадам эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү болон **ойрын садан** төрөл нь нас барсан тохиолдолд Улаанбаатар хотод ажлын 1-5, хөдөө орон нутагт ажлын 1-11 хоног /ойрын садан төрөл гэдэгт баримтаар нотлогдсон өөрийн болон хадам талын ургийн овог ижил өвөө, эмээ, нөхөр, эхнэртэй ургийн овог ижил хадам ах, эгч, дүү орно./
2. Төрүүлсэн эцэг, эх, нөхөр, эхнэр, үр хүүхэд, хадам эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү болон өөрөө гадаад дотоодын эмнэлэгт үзлэг шинжилгээнд хамруулах, сахих, асрах тохиолдолд эмнэлгийн нотлох баримтыг үндэслэн ажлын 1-11 хоног
3. Албан ёсны /албан бичиг ирсэн/ сургалт, хурал, зөвлөгөөн, семинар, сургуулийн цагдаагийн үүрэгт ажлыг гүйцэтгэх, спорт, урлагийн тэмцээн болон бусад зайлшгүй хүндэтгэн үзэх шалтгаантай үйл ажиллагаанд заасан хугацаагаар чөлөө олгоно.
4. Бусад тохиолдолд цалингүй чөлөө олгоно.

Жич: Дэд захирал, албадын дарга нар 4 цаг хүртэл, клиникийн эрхлэгч, багийн ахлагч нар 2 цаг хүртэл чөлөө олгоно.